



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Олон улсын сувилагчдын өдрийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.5, 8.1.6 дугаар зүйлийг үндэслэн, "Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги"-ийн хэрэгжилтийг хангах, олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулах зорилгоор ТУШААХ нь:

2. 2016 оны 05 дугаар сарын 12- ны өдөр тохиох олон улсын сувилагчдын өдрийг "Хэрэглэгчдэд ээлтэй-Сувилахуйн тусламж, үйлчилгээ" уриан дор орон даяар тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

3. "Хэрэглэгчдэд ээлтэй-Сувилахуйн тусламж, үйлчилгээ" уриан дор зохион байгуулах үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан арга хэмжээний тайланг хугацаанд нь ирүүлэх, холбогдох зардлыг хариуцан ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Энхболд)-т үүрэг болгосугай.


САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080355

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 09 сарын 31 өдрийн
Н.О.М дугаар тушаалын хавсралт



**“ХЭРЭГЛЭГЧДЭД ЭЭЛТЭЙ-СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ” УРИАН ДОР
ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

1. Зорилго:

Эрүүл мэндийн байгууллагууд хэрэглэгчдэд ээлтэй орчин, нөхцөл бүрдүүлснээр сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах,

2. Зорилт:

1. Эрүүл мэндийн байгууллагууд хэрэглэгчдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлсэн байдал, сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ, дүгнэлт өгөх,
2. Цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,

3. Зохион байгуулагч:

- ЭМСЯ,
- ДЭМБ,
- АХБ-ны Эрүүл мэндийн салбарын хөгжил-4 хөтөлбөр

4. Үйл ажиллагаа.

Эрүүл мэндийн байгууллагууд:

1. “Хэрэглэгчдэд ээлтэй- Сувилахуйн тусламж, үйлчилгээ” сэдвийн хүрээнд 2016 оны 3-аас 4 дүгээр улиралд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж, ажилласан байна.
2. Энэхүү ажлын хүрээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдалд доорхи хүснэгтэд заасан болон байгууллагын хэрэгцээнд суурилсан бусад асуудлаар үнэлгээ өгч, тулгамдсан асуудлаа тодорхойлж, хийх ажлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлж, ажилласан байна.
3. Сувилгааны албад, сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлаа дүгнэхдээ өөрийгөө үнэлэх зарчмыг баримтлан, доорхи аргачлалыг жишиг болгон 1-ээс 5 хүртэлх баллаар үнэлэх ба 1 – маш сул, 2- сул, 3- дунд зэрэг, 4- сайн, 5- маш сайн буюу тухайн чиглэлийн ажлуудын бодит тоонд харгалзуулсан байдлаар үнэлж, дүгнэсэн байна.

**4. “Хэрэглэгчдэд ээлтэй- сувилахуйн тусламж, үйлчилгээ” сэдвийн
хүрээнд 2016 онд хийсэн ажлыг үнэлэх жишиг үнэлгээ**

№	Ерөнхий чиглэл	Үйл ажиллагаа	Үнэлэх аргачлал
1	Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний удирдлага зохион байгуулалтын орчин	Сувилахуйн алба нь хэрэглэгчдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлэх, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах асуудлыг удирдлагын зөвлөлөөр шийдвэрлүүлсэн асуудал	Байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн асуудлын тоогоор үнэлнэ
		Сувилахуйн алба нь хүлээх чиг үүргийн дагуу хүний нөөцийн асуудлаар шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх эрх үүргийн биелэлтийн байдал	Шийдвэрлүүлсэн асуудлын тоогоор үнэлнэ
		Сувилахуйн алба нь хүлээх чиг үүргийн дагуу ажлын байрны таатай орчин нөхцөл бүрдүүлэх, бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл хийх чадамж	Энэ чиглэлээр авсан арга хэмжээний тоо, төрлөөр үнэлнэ
		Тусламж, үйлчилгээнд сувилахуйн асуудлаар гаргасан тушаал, журмын хэрэгжүүлсэн байдал	Тусгай жагсаалтаар хангана
2	Тусламж, үйлчилгээний чанар, орчин нөхцөл	Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээний ая тухтай, аюулгүй орчин нөхцөл бүрдүүлсэн байдал	Стратегийн /14-18 дугаар/ үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлаар үнэлнэ
		Тусламж, үйлчилгээг үзүүлэгчийн эрүүл, аюулгүй байдлыг хангасан байдал	Стратегийн /19-32 дугаар/ үйл ажиллагааны хэрэгжилт, хүрсэн үр дүнгээр үнэлнэ
		Сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцлийн үнэлгээ	
		Сувилахуйн албадаас санаачлан боловсруулж, батлуулсан байгууллагын дотор мөрдүүлэх стандарт, удирдамжийн тоо, төрөл	
		Сувилагчдын сувилгааны түүх хөтлөлтийн ур чадварт өгсөн үнэлгээ	Сувилагчдаас санаандгүй тохиолдлоор сонгож, дүгнэсэн үзүүлэлт, нийт сувилагчдын сувилгааны түүх хөтлөлтөд өгсөн үнэлгээ
		Сувилагчдын үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх чадварт өгсөн үнэлгээ	
		Сувилагчдын сувилгааны онош тавьсан байдалд өгсөн үнэлгээ	
Тухайн жилд сувилгааны оношийн			
	Сувилахуйн албанаас		

		зөрүүнд хийсэн үнэлгээ, хэлэлцүүлэг зохион байгуулсан байдал	сувилгааны онош тавьсан байдалд тогтмол хяналт тавьсан, Сувилахуйн оношийн зөрүүнд хийсэн хяналт, үнэлгээ, Сувилахуйн оношийг хэрхэн зөв тавих асуудлаар хэлэлцүүлэг, сургалт хийсэн байдал, Сувилагчдын онош тавьж байгаа чадварын үнэлгээ,
3	Сувилагч, эмнэлгий тусгай мэргэжилтний хөгжил, мэргэжлийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх асуудал	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанар, тогтмол байдал, мэргэжилтнийг хамруулсан хувь Мэргэжилтнүүдийг мэргэжил олгох сургалтад хамруулсан хувь Мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан хувь Мэргэжилтнийг урамшуулах асуудлаар авч хэрэгжүүлсэн ү/а	Эдгээрээс гадна стратегийн /33-37 дугаар/ үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлаар үнэлнэ
4	СТҮХ стратегийн хэрэгжилтийн дүн	Стратегийн шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, хүрсэн үр дүн	Шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувь
5	"Хэрэглэгчдэд ээлтэй сувилахуйн тусламж, үйлчилгээ" сэдвийн хүрээнд төлөвлөж хэрэгжүүлсэн бусад үйл ажиллагааны дүн		Төлөвлөсөн ажлын тоо, төрлөөр биелүүлсэн ажлын дүн
6	Бусад	"Сувилагчийн нэг өдөр"- аяныг зохион байгуулж хүрсэн үр дүн Дэвшилттэй үйл ажиллагаа Тулгамдсан 5 асуудал	Хэрэгжүүлж хүрсэн гол үр дүн Бодит үр дүнгээр Тодорхойлсон байна.

/СТҮХ Стратеги -Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх Стратеги/

Хяналт, үнэлгээ.

4.1 Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын сувилгааны албад:

4.1.1 Энэхүү удирдамжийн 4 дүгээрт заасан үнэлгээний дүгнэлт,

4.1.2 Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн тайлан,

4.1.3 2017-2022 онд сувилахуйн асуудлаар баримтлах бодлого, стратегид тусгах санал,

4.1.4 "Хэрэглэгчдэд ээлтэй сувилахуйн тусламж, үйлчилгээ" сэдвийн хүрээнд хийсэн бүтэн жилийн ажлын тайланг 2016 оны 11 дүгээр сарын 15-нд багтаан ЭМСЯ-ны Эмнэлгийн тусламжийн хэлтэст ирүүлнэ.

4.2 Олон улсын сувилагчдын өдөр тэмдэглэх хүрээнд жил бүр зохион байгуулж ирсэн "Сувилагчийн нэг өдөр" аяныг зорилтот бүлэг, нийгэмд хандан зохион байгуулсан байна.

4.2.1 Аймаг, нийслэлийн ЭМГ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд нь "Сувилагчийн нэг өдөр" аяныг тусгайлан хүргүүлсэн удирдамжийн дагуу зохион байгуулж, тайланг 2016 оны 05 дугаар сарын 1-ний дотор ЭМСЯ-ны Эмнэлгийн тусламжийн хэлтэст ирүүлнэ.

4.2.2 Тэргүүний арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгууллагыг 2016 оны 05 дугаар сарын 12 нд зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээний үеэр дүгнэж урамшуулна.